



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/184

Улаанбаатар хот

Нийслэлийн Ерөнхий боловсролын
“Голомт цогцолбор” сургуулийн
эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 19,232,735.26 (арван есөн сая хоёр зуун гучин хоёр мянга долоон зуун гучин таван төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Ерөнхий боловсролын “Голомт цогцолбор” сургууль (Р.Цэдэндамбаа)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж 315 нэр төрлийн 12,395 ширхэг нийт 19,232,735.26 (арван есөн сая хоёр зуун гучин хоёр мянга долоон зуун гучин таван төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн үнэ бүхий ном, сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Ерөнхий боловсролын “Голомт цогцолбор” (Р.Цэдэндамбаа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

М.БАЯРАА



Тушаал-2021

115050000561

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/18% дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Голомт цогцолбор сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Эвдрэл гэмтэл	Байгууллагын үнийн санал нэг бүрийн үнэ	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
Сурах бичиг											
1	Сурах бичиг 1-12 дугаар анги	4-14	ш	12,359	19,230,235.26	19,232,735.26	-	-	сургалтын агуулга, стандартаар өөрчлөгдсөн, хуудас дутуу урагдсан	устгах	устгах
Нийт данснаас хасах сурах бичиг											
Үүнээс: Худалдах хөрөнгө											
Устгах хөрөнгө											
Худалдсанаас олох орлого											